**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ЯАМ**
**БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН АЖЛЫН АЛБАНЫ**
**ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 28 өдөр Дугаар А/12 Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 2.4, 2.5, 2.7, Ажлын албаны Ёс зүйн дэд хорооны хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсролын зээлийн сангийн Ажлын албаны албан хаагчдын Ёс зүйн дэд хорооны гишүүдийг сонгох саналын дүнг үндэслэн, ёс зүйн дэд хорооны гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:
Ц.Доржсүрэн — Сургалтын дотоод зээл, тэтгэлэг хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүн:
П.Оюунцэцэг — Судалгаа шинжилгээ, статистик хариуцсан ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:
У. Цэцэгдэмбэрэл — Зээлийн эргэн төлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн

2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон бусад холбогдох хууль,дүрэм, журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнаж ажиллахыг Ёс зүйн дэд хороо (Ц.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, Ёс зүйн дэд хорооны ажиллах нөхцөл, боломжийг хангаж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (Ч.Дэчээ)-т үүрэг болгосугай.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ О.СИЙЛЭГМАА

9024080490 ☏ 5063145

1425010037